

10. Хүйсээр алагчлуулахгүй байх эрх

50. Хүн аль ч байдлаараа алагчлуулахгүй байх эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн холбогдох заалтуудаар тогтоосон бөгөөд мөн харилцааг цаашид Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиар зохицуулж буйгаас гадна Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг 2001 онд, Нийгмийн хамгааллын стратегийн баримт бичгийг 2003 онд тус тус батлан гаргаснаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг ажил хөдөлмөр эрхлэлтэд алагчлуулахгүй байх явдлаас урьдчилан сэргийлэх хууль, эрх зүйн үндсийг тавихад том алхам болсон.

51. 2008 оны байдлаар Монгол Улсын 7-29 насны нийт эрэгтэйчүүдийн 53.4 хувь, эмэгтэйчүүдийн 58.6 хувь нь сургуульд хамрагдаж байсан бол эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт эмэгтэйчүүдийнхээс 5.2 хувиар доогуур байна. Албан бус хэвшилд ажилладаг насанд хүрээгүй хүүхдийн 64.3 хувь нь хөвгүүд бөгөөд тэдний 58.7 хувь нь сургууль завсардаад байна. 18 нас хүрсэн залуучуудын 12 хувь нь бичиг үсэггүй, цэргийн үүрэгт алба хаагаагүй залуучуудын 20 хувь бичиг үсэгт тайлагдаагүй байна. Эдгээр тоо баримтууд нь Монгол Улсын хувьд хөвгүүдийн боловсрол охидынхоосоо хоцрогдож явааг харуулж байна.

52. Монгол Улсын хөгжил дэвшилд эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэгш оролцуулах, тэдний эрх тэгш байдлыг баталгаажуулах талаар төрийн зүгээс тодорхой бодлого барин ажиллаж байна. Тухайлбал, НҮБ-ын Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаас 2000 онд гаргасан Мянганы Тунхаглал болон Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс 2005 онд УИХ-аас "Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилт"-ыг баталсан. Үүнд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд хүйсийн ялгааг арилгах, хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхлэж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 50-д, парламентад эмэгтэй гишүүдийн эзлэх хувийг 30-д тус тус хүргэх зэрэг хүйсийн тэгш байдлыг хангах томоохон зорилтуудыг дэвшүүлжээ.

53. Монгол Улсын Засгийн газраас хүйсийн тэгш байдлыг хангах талаар хийж буй томоохон ажлуудын нэг бол "Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль"-ийн төслийг санаачлан боловсруулж, 2009 оны 7 дугаар сард УИХ-д өргөн бариад буй явдал юм. Монгол Улс жендерийн хөгжлийн индексээр 140 орноос 94-д, жендерийн эрх мэдлийн хэмжүүрээр 76 орноос 65-д орсныг дэлхийн хүний хөгжлийн илтгэлд дурдсан байна. Дэлхий дахинд тогтвортой хөгжлийг хангахад жендерийн тэгш байдал чухал үүрэгтэйг Монгол Улс хүлээн зөвшөөрч жендерийн чиг хандлагыг хөгжлийн бүхий л бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн тусгах явдалд онцгойлон анхаарч байна.